

Хятаны үеийн чулуун хөргийн онцлог шинжийн тухай мөчид шинжлэх нь

Содбилэг^{1,*}

Товч агуулга: Өнөөгийн БНХАУ-ын Өвөр Монгол орон бол Хятанчуудын мандаж бадарсан голомт нутаг юм. Хятанчуудын хүчирхэг их гүрний таван нийслэлийн хоёр нь Өвөр Монголд байдаг бөгөөд хаадын онгон, язгууртны булш, хот суурин, сүм суварга зэрэг археологийн олдворууд харьцангуй элбэг олддог. Харин Хятаны үеийн чулуун хөрөг маш цөөн олджээ. Тус өгүүлэлд Хятаны үеийн хэмээн үзэж буй чулуун хөргүүдийн зарим онцлог шинжийн тухай судлахыг оролдсон болно.

Түлхүүр үг: Хятан, хүн чулуу, чулуун хөрөг

Удиртгал

Чулуун хөрөг гэдэг нь эртний хүмүүсийн чулуугаар урлан бүтээсэн хүн дүрстэй хөшөө дурсгал болно. БНХАУ-ын Өвөр Монгол орны чулуун хөргийн түүх нь шинэ чулуун зэвсгийн үеэс Юань гүрний үе хүртэл үргэлжилсэн урт удаан түүхтэй боловч одоогоор бидний үед бүрэн бүтэн хадгалагдаж үлдсэн хүн чулуу цөөн байдаг. Эдгээрийн дотор, 1989 онд шинэ чулуун зэвсгийн үеийн 8000 жилийн өмнөх “Бухын голын соёл” (Шин Лүн Вагийн соёл)-ын үеийн Линш шианы “Баянцагаан буурь”-аас илрүүлсэн чулуун хүнээс Түрэг, Хятан, Монгол зэрэг олон үндэстний урлаж үлдээсэн чулуун хөрөг багтана. Эдгээр олдворууд нь Өвөр Монголд аж төрж байсан эртний хүмүүсийн чулуу цоолборлох урлагийн үнэт дурсгалт өв юм. Жишээлбэл, Улаанхад хотын Баарин баруун хошууны Баянхошуу балгасын Хулстай гацаанаас олдсон хүн чулуу Түрэгийн үеийнх, Улаанхад хотын Линш шианы Дүн бүү балгасын Гурван чулуут уул, Хөх хотын Сайхан дүүргийн Хуахашуу балгасын Чулуун хүний тохой гэдэг газраас олдсон хүн чулууд Хятаны үеийнх гэж үздэг (张兴国 275-277). Харин Юань гүрний үеийн чулуун хөргүүд Өвөр Монголын Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошууны Түмт, Шулуун хөх хошууны Бумбан завсар, Тарган шил зэрэг олон газраас олджээ.

Өвөр Монголын нутгаас Түрэг, Юань гүрний үеийн чулуун хөрөгтэй харьцуулахад Хятаны үеийн хүн чулуун хөшөө тун цөөн олдсон байна. Нийтийн он тооллын 907 онд Хятаны Елюй овгийн Абаожигэгч шалгарсан баатар эр тодрон гарч, эрх мэдлээ бэхжүүлэн Хятаны найман аймгийг нэгтгэж, засаг

захиргааны талаар таван нийслэлийн дүрэм, умард ордонд Хятанчууд буюу нүүдэлчдийг захирч, өмнөд ордонд суурьшмал хүмүүсийг заншлаар нь засах “нэг улс хоёр байгуулал”-ын дүрмийг хэрэгжүүлжээ. Хятан нар нүүдэлчин ард түмэн байсан бөгөөд Хятад орныг эзлэн суурин газрын соёлын олон зүйлийг авч хэрэглэж, газар тариалан, гар урлал, ялам хүр хорхой үржүүлэх мэдлэгийг дэлгэрүүлж, тэдний бүтээсэн хот балгад, сүм суварга, булш бунхан, чулуун хөрөг зэрэг түүх дурсгалт зүйлс манай үед олноор хадгалагдан ирсэн байна. Гэвч чулуун хөрөг нь түүхийн урт аяны улмаас улс төрийн донсолгоон, дайн байлдаан, байгалийн өгөршил идэгдэл, түүх соёлоо хайрлаж хамгаалдаггүй ухамсар дорой хүмүүсийн буруу ажиллагаанд өртөж, эвдэрч сүйдсэн байна. Зарим нь бүр барилгын материал, багаж зэвсэг болгож хэрэглэсэн шалтгаанаас бүрмөсөн алга болсон буюу дутуу зэрэмдэг, шарх сорвитой болж, ихэнх нь толгой нь хугаран алга болжээ. Тиймээс энэ өгүүлэлд Елюй Абаожийн Жулин онгоноос олдсон чулуун хөрөг, Елюй Жунгийн онгоны өмнөх чулуун хөрөг, Гурван Чулуут уулын чулуун хөрөг, Хөх хотын Чулуун хүний тохойн чулуун хөрөг зэрэг цөөн олдсон Хятаны үеийн хүн чулуун хөшөөдийг тоймлон, Хятаны чулуун хөргийн онцлог шинжийг гаргахыг оролдоё.

Елюй Абаожийн Жулин онгоноос олдсон чулуун хөрөг

Ляо улсын тулгар төрийг байгуулсан анхны хаан Елюй Абаожийн Жулин онгоны өмнө хөтлийн онгоны замаас өндөр нь 162 см, толгойгүй хүн чулуу болон хэвтэж байгаа чулуун нохойн цоолбор олдсон билээ (Зураг 1). Хүн чулуу нь харамсалтайгаар толгой нь хугаран алга болсноос гадна баруун мөрөөс доош хэсэг нь тасарч эвдэрчээ. Биедээ буруу энгэртэй, дугуй заамтай, бие барьсан нарийн ханцуйтай, хятан

¹ МУИС, Антропологи, Археологийн тэнхим, докторант, БНХАУ-ын Өвөр Монголын Хөх хот Үндэстний дээд сургуулийн Уран зургийн сургуулийн багш

* Холбоо барих зохиогч: 20D1NUM0077@stud.num.edu.mn



Зураг 1. Елюй Абаожийн Жулин онгоны өмнө хөтлийн онгоны замаас олдсон хүн чулуу ба чулуун нохойн цоолбор

үндэстний уламжлалт тэрлэг өмссөн. Дээлийн зах болон хормойн хэсгээр үл мэдэгдэм эмжээртэй. Дөхөм боловч нүдэнд ээлтэй тун чадварлаг сийлбэртэй. Хормой нь төдий өргөн биш гутлын түрий давсан урт ажээ. Гутал нь нүүдэлчдийн өмсдөг эсгий гуталтай адил. Хүн дээлийн гадуур бөсөөр хийсэн бүс бүслэж хэвлийн өмнө өлзий утас шиг зангилаа гаргасан. Хэвлийн өмнө зүүн гараар баруун гарын сарвуугаа атган зогсож байна. Хүний гарын сарвуу болон хурууны дүрслэлийг маш амьдлаг нарийлаг сийлжээ. Хүн чулуунд ямар нэг эд хэрэглэлийн зүйлс дүрслээгүй (Зураг 1b).

Чулуун хөргийн хажуугаас өндөр нь 36 см, өргөн нь 71 см хэмжээтэй, чулуун нохой олдсон нь хааны ойр зуурх анчин баатрын дүр эсвэл нохойтойгоо хамт онгоны эзний ариун сүнснийг сахин хамгаалж байгаа бэлгэдэл утгатай ажээ (Зураг 1a). Нохой бол нүүдэлчдийн өдөр тутмын малжих амьдрал болон ан агналд дутагдашгүй шударга хань билээ.



Зураг 2. Елюй Жунгийн онгоны бичиг цэргийн түшмэдийн чулуун хөрөг



Елюй Жунгийн онгоны бичиг цэргийн түшмэдийн чулуун хөрөг

Өвөр Монголын Улаанхад хотын Харчин хошууны Ший Чяо Шиангийн Ге Зи Тянь тосгоны баруун өмнө 1 километр орчмын уулан хөтөлд Елюй Жунгийн онгоны өмнө, баруун зүүн хоёр гарын бичиг, цэргийн түшмэд, чулуун хонь, бар, хөшөө зэргээс бүрдсэн чулуун сийлмэлүүд олдсон байдаг. (Зураг 2a). Елюй Жун нь Ляо улсын анхны хаан Елюй Абаожийн гуравдугаар дүү бөгөөд Ляо улсын өмнөд хэсгийн Зүожегийн гэрэг мэдэгчийн тушаалыг хариуцаж байсны зэрэгцээ Жьет Ши түшмэлийн зэрэг дээд тушаалыг хавсарган хариуцаж байв. Тэрбээр Хятаны



хаан угсааны язгууртан байсан бөгөөд Ляо улсын Жин Жун Бүү Юаны арван нэгдүгээр он буюу нийтийн он тооллын 979 онд нас баржээ (穆红鹤35, 36).

Онгоны хоёр түшмэлийн нэгийн нь толгойн хэсэг ихээхэн эвдэрсэн, нөгөө нь үндсэндээ бүрэн бүтэн хадгалагдаж үлджээ. Бичгийн түшмэлийн тэргүүнд бөмбөгөр оройтой тоорцог малгай өмсгөж, нүүр, нүд, ам, хамар зэргийг маш тодорхой гаргажээ. Нүд нь бүлтгэр, ам нь жижигхэн сийлбэртэй. Биедээ зөв энгэртэй, жишүү заамтай, өргөн нэлэмгэр ханцуйтай хувцас өмссөн. Цэргийн түшмэл нь өргөн дугуй махлаг царайтай, өтгөн хөмсөгний доор бүлтгэр нүдтэй, хамар нь өндөр, хийц уран бөгөөд толгой бие нь бүтнээрээ хадгалагдсан Хятаны үеийн чулуун хөргийн ховор дурсгал юм. Нүүр царайг маш бодитой чадварлаг урласан нь хүний жинхэнэ төрхийг харуулсан гэмээр байдаг. Малгай нь бөмбөгөр оройтой, хоёр талын чихэвч нь мөртөө хүртэл унжсан, бүх биедээ өвч хуяг өмссөн, өндөр түрийтэй гуталтай. Хоёр гараар хэвлийн өмнө илднийхээ бариулаас атган газар тулж зогссон байдалтай. Монголжуу царайтай Хятаны дайчин эр болох юм (Зураг 2b). Харамсалтай нь Елюй Жунгийн онгоны бичиг цэргийн түшмэдийн чулуун хөрөг 2007 оны 9 дүгээр сарын 13-нд хулгайд алдагджээ.

Гурван чулуут уулын Хятаны үеийн хүн чулууд

Энэ чулуун хөрөг нь Улаанхад хотын Линьши сяний Дүн Бүү Балгасын Гурван чулуут уулын ар талын үерийн усанд гарсан судгийн аманд сул хэвтэж бий (Зураг 3). Гурван чулуутын ууланд байгалийн боржин чулуугаар цавчиж сийлсэн Хятаны үеийн бичиг цэргийн түшмэлийн хоёр чулуун хөрөг болон хоёр чулуун хонь байдаг. Нэгдүгээр чулуун хөрөг нь цээжин өмнөө хоёр гараараа хавтас атган барьсан бичгийн түшмэл байж, хоёрдугаар чулуун хөрөг нь өмнөө хоёр гараараа илдний ишнээс барьж, үзүүрийг нь торгон барьсан цэргийн түшмэл болно.

Өмсгөл зүүсгэлийг нь ажиглавал, газар шүргэх дээлийн хормойн доороос гутлын хоншоор ялимгүй үзэгдэж, хоолой орчимд дугуй заамтай. Иймэрхүү дугуй заамтай өмсгөл Хятаны үеийн бунхны ханын зурагт элбэг харагддаг. Маш өргөн нэлэмгэр ханцуйтай бөгөөд гарын үзүүрээс өвдөг давтал доош унжиж, хөшөөний доод хэсгийг газарт буюу тусгай чулуун сууринд зоож суулгах зорилготой дөрвөлжин углуурга мэт зүйл гарган засжээ.

Хоёр чулуун хонины төрх байдал нь адилхан, урлаж сийлсэн нь төстэй. Чулуун хөрөг болон хонины толгой хугарч алга болжээ. Нутгийн тариачдын яриагаар уг чулуун хөргүүдийг шүтэж, настайчууд ер нь хүүхэддээ гар хүргүүлдэггүй байсан боловч 1970-аад оны үеэр чулуун хөрөг болон хонины толгойгоор



Зураг 3. Гурван чулуут уулын Хятаны үеийн хүн чулууд

тариан зурхай хатууруулахад хэрэглэдэг чулуун бул хийсэн гэж ярьдаг. Иймэрхүү жишээ Өвөр Монгол оронд цөөнгүй байдаг.

Онгон булшны өмнө чулуун хонь байрлуулах зан үйл нь бараг 1000 гаруй жилийн өмнөх Түрэгийн хаант улсаас ирэлтэй. Хонь бол эртнээс нүүдэлчин үндэстний өдөр тутмын амьдралын үндсэн баталгаа байсан тул маш чухалчилж үздэг байсан гэж эрдэмтэд онцлон тэмдэглэсэн байдаг (Коновалов 2015: 21).

Хөх хотоос олдсон Хятаны үеийн хүн чулуун хөшөөд

Өвөр Монголын Хөх хотын Сайхан дүүргийн Хуахашуу балгасанд Чулуун хүний тохой гэдэг нэртэй газар бий. Газрын нэрийдэл нь энд танилцуулах хүн хөргүүдээс ирэлтэй юм. Чулуун хүний тохойд өөд өөдөөс нь харуулан зогсоосон мэт байрлуулсан уран чадварлаг хийсэн хоёр хүн чулуун ба хөсөр хэвтсэн чулуун хонь байдаг. Тус хоёр чулуун хөргийн хийсэн материал, янз хэлбэр ба урласан арга маяг нь үндсэндээ адилхан, өндөр нь бараг 1.8 м байдаг. Харамсалтай нь чулуун хөрөг болон хонины толгой нь 2000 оны эхээр тоноочдоод хулгайлагджээ (张兴国 275-277). Урласан арга маягаас үзвэл, одоос 1000 гаруй жилийн өмнөх Ляо улсын үеийн хаан угсаатан буюу язгууртны булшны өмнө босгосон зүйлс байж, энэхүү дурсгал бол Хөх хот орны одоо болтол газар дээр илээр мэдэгдээд байгаа цорын ганц Хятаны үеийн булш болно. Тус хүн чулууд нь Улаанхад хотын Линш шианы Дүн бүү балгасын Гурван чулуут уулын хүн чулуудтай нилээд төстэй боловч сийлбэрийн зураас гүн мөртөө тод, дээлийн энгэр заам төдий тодорхой гаргаагүй, дөрвөлжин хээтэй ширэн бүсний ар өвөр талд эрвээхийн зангилаатай унжлагатай. Бичгийн түшмэл нь баруун сугандоо гүйлсэн цэцэг хэлбэртэй засал зүүж, цэргийн түшмэл нь баруун сугандоо сэлэм сугавчилж, цээжин өмнөө хоёр гартаа чандмань атгажээ. Доод суурь нь газарт зоолттой тул дээлийн хормойн хязгаар ба хүний хөлийг зэргийг яаж дүрсэлсэн нь тодорхойгүй.



Зураг 4. Хөх хотоос олдсон Хятаны үеийн хүн чулуун хөшөөд

Хаант Орос улсын монголч эрдэмтэн А.М.Позднеев 1893 оны 3 дугаар сарын 8 болон 17-нд энэхүү чулуун хөрөгт хоёр удаа байцаалт шинжилгээ хийж, “Монгол ба монголчууд” гэх долоон боть аяллын тэмдэглэлийнхээ 2-р ботид хүн чулууны тухай тайлбар хийснээр барахгүй ардын хууч яриа, гэрэл зургуудыг хавсаргасан байдаг (Позднеев 1898: 123-124).

Хятаны үеийн чулуун хөргийн онцлог шинж

Монголын нэрт эрдэмтэн Д.Баяр “Монголчуудын чулуун хөрөг” бүтээлдээ: “Аливаа төрлийн чулуун хөргийн хийц загварыг судлахад юуны өмнө, хүмүүний дүрсийг үйлдэхдээ бүтэн биеийн дүрстэй буюу хагас байдлаар дүрсэлсний аль нь болохыг анхаарах нь чухал” гэжээ (Баяр 2012: 144). Одоогоор Өвөр Монгол орноор олдоод байгаа Хятаны үеийн хүн чулуун хөшөөдийн хийц загварыг судалж үзвэл, нийтэд нь бүтэн биеийн дүрстэй байна. Түрэг, Уйгур, Юань улсын үеийн хагас байдлаар дүрсэлсэн, сандалт хөрөг, эмэгтэй хүнийг дүрсэлсэн хүн чулуу хараахан олдоогүй. Евразийн нүүдэлчдийн хүн чулууг тусгайлан судалсан эрдэмтдийн бүтээлээс үзэхэд, чулуунд дүрсэлж гаргасан зүйлс (хувцас, гоёл чимэглэл, зэр зэвсэг, ахуйн хэрэгцээт зүйлс) нь тухайн үеийн холбогдох он цаг болон түүх соёлын хамааталыг тодруулахад найдвартай түүхэн сурвалж болдог байна (Баяр 2012: 113).

Түрэг болон Монголын хүн чулуу ихэвчлэн цээжин өмнөө гартаа хундага савын зүйлс барьж

байдаг байхад Хятаны үеийн хүн чулууны онцлог гэвэл бичгийн түшмэл хавтас буюу чандмань, цэргийн түшмэл илдний ишнээс хоёр гардан барьж зогссон байна. Жулин онгоны хүн чулуу хоёр гараа хэвлийн өмнө зөрүүлэн атгасан байдлаар дүрсэлсэн байна. Дүрсэлж гаргасан эд юмсын талаас нь үзвэл, Хятаны үеийн хүн чулууны гарт бариулсан хэрэглэгдэхүүн нь хавтас, чандмань, илд байж, Елюй Жунгийн онгоны бичгийн түшмэл нь тоорцог маягийн малгайтай, цэргийн түшмэл нь тэргүүндээ дуулга өмссөн, Жулин онгоны чулуун хөрөг хэдийбээр толгой хугарсан боловч нуруун ар дээрх урт гоёлын дүрслэл тодхон харагдаж бий. Бусад нь толгой үгүй болсон учраас малгай, гоёл, нүүрний дүрслэлийг тодорхой хэлэх аргагүй болжээ. Хувцас өмсгөлийн талаар Жулин онгоноос олдсон ба Елюй Жунгийн онгоны цэргийн түшмэлийг гаргавал, дээл хувцас нь уужим, ханцуй халхагар өргөн бөгөөд гарын үзүүрээс доош тунаран унжсан байдалтай дүрсэлж, бүснээс зүүсэн хавтага сав, зэр зэвсэг зэрэг эд хэрэглэлийн зүйлс огт байхгүйгээр ялгардаг. Иймэрхүү өмсгөл зүүсгэл нь Түрэг ба Юань улсын үеийн монгол хүн чулуутай эрс ялгаатай байна. Хүн чулуун хөшөөнд гутал дүрслэх нь Түрэгийн дурсгалд бараг тохиолддоггүй (Баяр 2012: 73) бол Хятаны хүн чулуунд бүгдээрэнд нь дүрслэгдсэн байна. Материалын талаар эдгээр Хятаны үеийн хүн чулуу нь байгалийн боржин чулуу буюу хар хүрмэн чулуу ашиглаж, Юань улсын үеийн шиг гантиг чулуун сийлбэртэй хүн чулуу хараахан олдоогүй.

Товч дүгнэлт

Хятанчууд нь өвөг дээдсийнхээ тахил тайлгын ёсыг чанд хадгалан баримталдаг, нүүдэлчдийн эсгий гэрийг дууриалган хийсэн, дотроо үзэмжит сайхан ханын зураг бүхий онгонуудыг байгуулж, булшны бүрэлдэхүүнд пайлуур хөшөө, хүний болон адгуус амьтны хэлбэрт чулуун цоолбор дүрсийг урлан хийж тавих тогтсон дэг ёстой байжээ. Гэсэн хэдий ч, Ляо улсын хүн нас барагсдынхаа булшны өмнө хүн чулуу босгох зан үйл ховор байсан бөгөөд одоогийн байдлаар цөөхөн хэдэн жишээ л олдсон байна. Жич, Ляо улсын Жулин онгоноос толгой нь хугарч алга болсон хүн чулуу ба чулуун нохой илрүүлсэн боловч сүүлчийн үеийн хаадын онгоноос ийм зүйл олдоогүй. Мөн Сүн улс болон Алтан улсын үеийн булш бунхны өмнө хүмүүн чулуун хөшөө босгох зан үйлтэй ч нилээд их зөрөөтэй байж, Ляо улсын үеийн язгууртан буюу дээд түшмэдийн онгоны өмнө хүн чулуун хөшөө босгох бодит жишээ ч тун цөөн байжээ.

Abstract

A Study of the characteristics of Khitan period stone statues

Caodubilige

Today's Inner Mongolia of the PRC is a place of Khitan flourishing. Two of the five capitals of the Liao empire are located in Inner Mongolia and archaeological sites such as royal virgins, noble tombs, urban settlements, and temples are relatively abundant. However, stone portraits from the Khitan period have been found very rarely. This article attempts to explore some of the characteristics of stone portraits that are considered to be from the Khitan period.

Keywords: Inner Mongolia, Liao dynasty, Khitan, stone statues

Ном зүй

Баяр, Д. (2012). Монголчуудын чулуун хөрөг. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо, Хөх хот.

Коновалов, П.Б. (2015). Монголын өндөрлөгийн археологи судлал. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо, Хөх хот.

Позднеев, А.М. (1898). Монголия и монголы: Результаты поездки в Монголию, исполненные в 1892-1893 гг. А. Позднеевым. Т. 2: Дневник и маршрут 1893 года. Санкт-Петербург.

张兴国, 李学良, 辽上京附近的两处辽代神道石像生, 宋史研究论丛 第11辑, 275-277

穆红鹤, 宋辽金墓上设施的考古学观察, 吉林大学硕士学位论文, 35页, 图36.

Received: Oct. 11, 2024; Revised: Nov. 18, 2024; Accepted: Dec. 16, 2024

